



ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2020 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 119

Ховд

“Хүндэт тэмдэг”-ээр
шагнах тухай

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны “Аймгийн шагналын журам” батлах тухай 28 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 3.1.4, 4.1.1 дахь заалт, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэхэд болон эрхэлсэн ажилдаа амжилт гаргаж ажиллаж буй дараах нэр бүхий иргэдийг Ховд аймгийн “Хүндэт тэмдэг”-ээр шагнасугай. Үүнд

- | | |
|-------------------|------------------------------------------------------------------------|
| 1. Ж. Лхагва | - Мөст сумын өндөр настан |
| 2. Б. Өлзийбаяр | - Мөст сумын өндөр настан |
| 3. А. Дашзэвэг | - Цэцэг сумын өндөр настан |
| 4. Ш. Долгор | - Цэцэг сумын өндөр настан |
| 5. О. Шайзат | - Ховд сумын Дунд-Ус багийн иргэн |
| 6. О. Мейрамхан | - Ховд сумын Дунд-Ус багийн иргэн |
| 7. С. Солдатхаан | - Буянт сумын Нарийн хайрхан багийн иргэн |
| 8. К. Жанболат | - Жаргалант сумын Наран багийн иргэн |
| 9. К. Базарбек | - Жаргалант сумын Наран багийн иргэн |
| 10. П. Отгонцэцэг | - Ус цаг уур орчны шинжилгээний газрын мэргэжилтэн |
| 11. Н. Булгаа | - Жаргалант сумын Жаргалан багийн өндөр настан, Улсын аварга тариаланч |
| 12. Ж. Баттөмөр | - Ерөнхий боловсролын сургуулийн багш |
| 13. Н. Шинэтуяа | - Ерөнхий боловсролын сургуулийн багш |
| 14. М. Отгончимэг | - Зэрэг сумын ЭМТ-ийн эрхлэгч эмч |

- | | |
|--------------------|-------------------------------------------------|
| 15. С. Дамчаа | - Зэрэг сумын ЗДТГ-ын жолооч |
| 16. Д. Тэрбиш | - Манхан сумын Ботгон багийн малчин |
| 17. Ж. Бямбажав | - Манхан сумын сургуулийн манаач |
| 18. Б. Цэрэнсодном | - DPP баяжуулах үйлдвэрийн ажилтан |
| 19. Э. Мянгандүгэр | - DPP баяжуулах үйлдвэрийн ажилтан |
| 20. Б. Ганзориг | - DPP баяжуулах үйлдвэрийн ажилтан |
| 21. П. Банзрагч | - Жаргалант сумын Жаргалан багийн
иргэн |
| 22. Ж. Үйсилхан | - Ховд аймгийн Жаргалант сумын иргэн |
| 23. И. Даваа | - Жаргалант сумын Баатархайрхан
багийн иргэн |
| 24. Н. Цогтбаатар | - Жаргалант сумын Баатархайрхан
багийн иргэн |
| 25. Д. Күлимхан | - Ховд сумын Эрүүл мэндийн төвийн
үйлчлэгч |
| 26. Д. Хархүү | - Мөст сумын сум дундын эмнэлэгийн
жолооч |
| 27. У. Пүрэвсүрэн | - Манхан сумын эрүүл мэндийн төвийн
үйлчлэгч |
| 28. Н. Жаргалдаваа | - Мянгад сумын эрүүл мэндийн төвийн
жолооч |
| 29. О. Балжинням | - Жаргалант сумын иргэн |
| 30. Р. Цэрмаа | - Манхан сумын иргэн |

ХУРЛЫН ДАРГА



Г. ПҮРЭВГАНДИ



ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2020 оны 05 сарын 26 өдөр

Дугаар 120

Ховд

Компанийн үүсгэн байгуулагчаар
оролцох тухай


Аймгийн эдийн засгийн чадавхыг сайжруулах, дотоодын нийт бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх, инновац технологийг хөгжүүлэх, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрлэлийг хөгжүүлэх, шинээр ажлын байр бий болгох зорилго бүхий орон нутгийн өмчийн оролцоотой хамтарсан компани байгуулах тухай аймгийн Засаг дарга Б.Дүгэржавын санал болон “Шинэ Ховд үйлдвэрлэл технологийн парк” ХХК-ий хүсэлтийг тус тус хэлэлцээд Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-ын “З”, 20 дугаар зүйлийн 20.1.7, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.4, 77.3 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Шинэ Ховд төслийн хүрээнд Ховд аймгийн Жаргалант сумын Бичигт багийн нутаг дэвсгэрт хэрэгжүүлж буй хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэн явуулахтай холбоотойгоор “Шинэ Ховд үйлдвэрлэл технологийн парк” ХХК-ий гаргасан хувьцааны 30 хувийг үнэ төлбөргүй, зардал гаргахгүйгээр аймагт эзэмшүүлж, хамтран ажиллах гэрээ байгуулах тухай саналыг зөвшөөрч “Шинэ Ховд үйлдвэрлэл технологийн парк” орон нутгийн өмчийн оролцоотой ХХК болгон өөрчлөхийг дэмжсүгэй.

2. Орон нутгийн өмчийн оролцоотой компанийн дүрмийг шинэчлэн боловсруулж аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээр хэлэлцүүлэхийг аймгийн Засаг дарга /Б.Дүгэржав/-д, “Шинэ Ховд үйлдвэрлэл технологийн парк” ХХК-ий үүсгэн байгуулагчдад тус тус даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ПҮРЭВГАНДИ



ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2020 оны 05 сарын 26 өдөр

Дугаар 121

Ховд

Санал дэмжих тухай

Үйлдвэрлэл технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.6 дахь заалтыг үндэслэн аймгийн Засаг даргын саналыг хэлэлцэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Ховд аймгийн Жаргалант сумын Бичигт багийн нутаг дэвсгэрт хэрэгжүүлж буй хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг “Шинэ Ховд үйлдвэрлэл технологийн парк” орон нутгийн өмчийн оролцоотой ХХК-д олгуулахаар ирүүлсэн саналыг дэмжсүгэй.

2.Паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Монгол улсын Засгийн газарт уламжлан шийдвэрлүүлэхийг аймгийн Засаг дарга /Б.Дүгэржав/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА Г.ПҮРЭВГАНДИ





ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2020 оны 05 сарын 26 өдөр

Дугаар 122


Ховд

Менежментийн төлөвлөгөө
батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 18.1.2-ын а, е, ж, з, л, 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалт, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1, Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөрийн 3 дугаар зүйлийн 3.7 дэх заалт, аймгийн Засаг даргын саналыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.“Сутай хайрхан уулын байгалийн нөөц газрын менежментийн төлөвлөгөө”-г хавсралтаар баталсугай.

2.Менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга /Б.Дүгэржав/-д даалгасугай.



ХУРЛЫН ДАРГА

Г.ПҮРЭВГАНДИ



ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2020 оны 05 сарын 26 өдөр

Дугаар 124

Ховд

Боловсрол, соёл, урлагийн салбарын талаар
авах зарим арга хэмжээний тухай

Аймгийн боловсрол, соёлын талаар хэрэгжүүлж буй бодлого, хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн талаар Боловсрол, соёл, урлагийн газрын дарга М.Пүрэвхүү, Насан туршийн боловсрол төвийн хийж хэрэгжүүлсэн ажлын талаар Насан туршийн боловсрол төвийн захирал Ц.Оюунцэцэг нарын мэдээллийг хэлэлцээд:

Ерөнхий боловсролын болон сургуулийн өмнөх боловсролын сургуулийн сургалтын чанар, хүрэлцээг сайжруулах, хүүхдийн хөгжлийн төв болгон хөгжүүлэхэд чиглэсэн “Чадварлаг Ховдчууд”, “Олон нийтийн оролцоот сургууль-хүний хөгжлийн төв”, “Хүүхэд бүр цэцэрлэгт”, “Олон үндэстний өв соёл”, “Цахим номын сан”, “Оюун түлхүүр” дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг иргэд олон нийтэд сурталчлах ажлыг өргөжүүлж, тэдний бүтээлч оролцоог тогтмолжуулах, насан туршийн боловсролын үйл ажиллагааг өргөжүүлэх, зарим сумдын сургуулийн хүүхдийн тоо цөөрч байгаа, соёл урлагийн салбарын байгууллагын хүний нөөц, төсөв, санхүү дутагдалтай байдаг зэрэг нь үйлчилгээний чанар, хүртээмжид муугаар нөлөөлж болзошгүй байгааг ТЭМДЭГЛЭЭД:

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2 дахь заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. Аймгийн Засаг дарга /Б.Дүгэржав/-д ҮҮРЭГ БОЛГОХ нь:

1.Боловсролын салбарын чанарын шинэчлэлийн хүрээнд ерөнхий боловсролын сургуулиудын бүтэц, хэв шинжийг оновчтой болгох, аймгийн төв болон аймагт ойрхон сумын сургуулийг тодорхой шинжлэх ухаан, урлаг, гоо зүйн төрөлжсөн, олон улсын хөтөлбөртэй сургуулиудын загвар хөтөлбөрөөр хөгжүүлэх хэтийн төлөвлөлтийг аймгийн хөгжлийн хөтөлбөр, төлөвлөлттэй уялдуулан боловсруулж хэрэгжүүлэх;

2.Хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн нэг ангид байх хүүхдийн тоо, стандартад нийцүүлж сургууль, цэцэрлэгийн шинэ барилга, өргөтгөлийг төлөвлөн барих асуудлыг судалж шийдвэрлэх;

3.Насан туршийн боловсролын төвийн үйл ажиллагааг өргөжүүлж байр, танхимаар ханган, тогтмол зардлыг жил бүрийн орон нутгийн төсөвт тусган, үйл ажиллагааг өргөжүүлэхэд аймаг, орон нутгийн төсвөөс дэмжлэг үзүүлэх;

4.Аймгийн Хөгжимт драмын театр, Номын сан, Орон нутгийг судлах музейн үйл ажиллагааг мэргэжил арга зүйн шуурхай удирдлагаар хангах, хүний нөөц, бүтэц, орон тоог оновчтой болгох, сумдын соёлын төвүүд, бусад байгууллагуудын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, төсөв санхүүгийн төлөвлөлтийг уялдуулан зохицуулах;

Хоёр. Аймгийн Боловсрол, соёл, урлагийн газрын дарга /М.Пүрэвхүү/-д ҮҮРЭГ БОЛГОХ нь:

1.Ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэгийн сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт үнэлгээ хийж, орон нутгийн онцлог хэрэгцээ, дэлхийн иргэн болоход шаардагдах ур чадварыг хүүхэд бүрд эзэмшүүлэх олон талын оролцоот менежментийг бүх сургалтын байгууллагуудад нэвтрүүлж, өөрийн удирдлагын байгууллагын үйл ажиллагааг сайжруулах;

2.Хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн мэргэжлийн багш нарын эрэлт, хэрэгцээний ойрын болон хэтийн судалгааг нарийвчлан гаргаж, шаардлагатай багш, мэргэжилтнийг жил бүрийн их дээд сургуулийн элсэлтийн захиалгад оруулан бэлтгэх, багш ажилтнуудыг чадавхжуулах сургалтын чанар үр дүнг сайжруулах;

3.Насан туршийн боловсролын үйл ажиллагааг өргөжүүлэх, дүйцсэн сургалтын агуулга, арга зүйн хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулж сургуулийн гадна байгаа хүүхэд залуус, бичиг үсэг үл мэдэгчдийн судалгааг нарийвчлан гаргаж, албан бус сургалтад бүрэн хамруулах;

4.Соёл урлагийн байгууллагуудын соён гэгээрүүлэх нөлөөллийг дээшлүүлж, мэргэжлийн уран бүтээлчдийн хангалтыг сайжруулах, мэргэжил арга зүйн удирдлагын шуурхай байдлыг хангаж соёл урлагийн үйлчилгээний төрөл, хэлбэрийг орон нутгийн онцлог, хэрэгцээнд нийцүүлэн нэмэгдүүлэх;

5.Салбарын хэмжээнд хэрэгжүүлж байгаа ажлын тайлан, мэдээлэл, дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг олон нийтэд сурталчлан, хүүхэд бүрийг хөгжүүлэх үйл ажиллагааны чанар үр дүнг сайжруулах зорилтот үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжилтийг хагас бүтэн жилээр тайлагнах;

Гурав. Аймгийн Насан туршийн боловсролын төвийн захирал /Ц.Оюунцэцэг/-д ҮҮРЭГ БОЛГОХ нь:

1.Иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн боловсрол олгох сургалтуудыг орон нутгийн мэргэжлийн байгууллага, холбоодтой хамтран цахим орчин, дэвшилтэд технологи, арга зүйгээр зохион байгуулах ажлыг өргөжүүлэх;

2.Насан туршийн боловсролын мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх, мэргэшүүлэн чадваржуулах;

Дөрөв. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга /Б.Сандагсүрэн/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ПҮРЭВГАНДИ



ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2020 оны 05 сарын 26 өдөр

Дугаар 125

Ховд

Зэрэг сумын Ерөнхий боловсролын
сургуулийг Чулууны Далайн
нэрэмжит болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14 дэх заалт, аймгийн Засаг дарга болон Зэрэг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын саналыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Түүхт 80 жилийн ойг тохиолдуулан Зэрэг сумын Ерөнхий боловсролын сургуулийг Монгол улсын Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, Шинжлэх ухааны академийн сурвалжит гишүүн, академич, түүхийн ухааны доктор, профессор Чулууны Далайн нэрэмжит болгосугай.

2.Монгол улсын Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, академич, түүхийн ухааны доктор, профессор Ч.Далайн намтар, бүтээл туурвилыг иргэд, олон нийтэд өргөнөөр сурталчлан, нийтийн хүртээл болгож, алдар гавьяаг нь мөнхжүүлж, алдаршуулж ажиллахыг Зэрэг сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал /Н.Галаа/-д үүрэг болгосугай.



ХУРЛЫН ДАРГА

Г.ПҮРЭВГАНДИ



ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2020 оны 05 сарын 26 өдөр

Дугаар 126

Ховд

Төрийн дээд шагналаар шагнуулахаар
өргөн мэдүүлэх тухай

Монгол улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлиг, Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.8 дахь заалт, Зэрэг сумын ИТХ-ын санал, аймгийн Засаг даргын саналыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Ховд аймгийн Зэрэг сумын Ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилчдын уйгагүй хөдөлмөр зүтгэл, үе үеийн удирдлагуудын оновчтой бодлого төлөвлөлтийн үр дүнд улс эх орон, сум орон нутгийнхаа хөгжил цэцэглэлт, бүтээн байгуулалтад үнэтэй хувь нэмэр оруулж, сургуулиа өдрөөс өдөрт өргөжүүлэн хөгжүүлж буй сургуулийн хамт олны ажлын амжилтыг өндрөөр үнэлэн түүхт 80 жилийн ойг нь тохиолдуулан Ховд аймгийн Зэрэг сумын Ерөнхий боловсролын сургуулийг Төрийн дээд шагнал “Алтан гадас одон”-гоор шагнуулахаар Монгол улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлсүгэй.

2. Ховд аймгийн Зэрэг сумын Ерөнхий боловсролын сургуулийг Төрийн дээд шагнал “Алтан гадас одон”-д тодорхойлсон холбогдох баримт бичгүүдийг журмын дагуу бүрдүүлж Монгол улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүлэхийг аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга /Б.Сандагсүрэн/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ПҮРЭВГАНДИ



ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2020 оны 05 сарын 26 өдөр

Дугаар 127

Ховд

Төрийн дээд шагналаар шагнуулахаар
өргөн мэдүүлэх тухай

Монгол улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлиг, аймгийн Засаг даргын санал, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол, тэмдэглэлийг үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Улс нийгэмдээ олон жил идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж байгаа дараах хүмүүсийг төрийн дээд шагналаар шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлсүгэй. Үүнд:

Монгол Улсын “Гавьяат мал зүйч”-ээр

1. Зандаа Тоня Ховд аймгийн Алтай сумын “Мэнд сүрэг”
мал эмнэлэг үржлийн газрын захирал

Монгол Улсын “Гавьяат эдийн засагч”-аар

1. Ойдов Баттулга - Жаргалант сумын Магсаржав багийн өндөр
настан

“Сүхбаатарын одон”-гоор

1. Лхагважав Аюурзана - Жаргалант сумын Хайрхан багийн өндөр
настан

“Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон”-гоор

1. Пүрэвдорж Долгор - Аймгийн Засаг даргын Тамгын газрын
архив бичиг хэргийн эрхлэгч
2. Зана Лхагвасүрэн - Чандмань сумын Засаг даргын Тамгын
газрын ХАА-н тасгийн дарга
3. Халхабек Амантай - Булган сумын Нэгдсэн эмнэлгийн өндөр
настан
4. Еэшээ Зоригоо - Ховд олон улсын нисэх буудлын жолооч

“Цэргийн гавьяаны улаан тугийн одон”-гоор

1. Хоролжав Шинэбаяр - Жаргалант сумын Бугат багийн өндөр настан

“Алтангадас одон”-гоор

1. Гап Долгормаа - Жаргалант сумын Бичигт багийн өндөр настан
2. Минжгээ Цовоо - Үенч сумын Нарийн гол багийн малчин
3. Цагаач Давааням - Аймгийн санхүү төрийн сангийн хэлтсийн ерөнхий нягтлан бодогч
4. Бямбажав Ганболд - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа удирдлагын хэлтсийн дарга
5. Содном Дорж - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн
6. Дүүдэй Батжаргал - Аймгийн Засаг даргын Тамгын газрын жолооч
7. Гиваа Баянмөнх - Чандмань сумын тахилт багийн малчин
8. Дамдин Оюунчимэг - Аймгийн мал эмнэлгийн газрын хяналт шинжилгээ үнэлгээ хариуцсан мэргэжилтэн
9. Дорж Янжмаа - Зэрэг сумын “Зэрэг буйлааст” хоршооны мал зүйч
10. Ишжамц Алимаа - Зэрэг сумын Ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн багш
11. Даахай Эрдэнэцэцэг - Зэрэг сумын Ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн багш
12. Хүрэлбаатар Сэрдамба - Эрдэнэбүрэн сумын Хонгио багийн малчин
13. Дамдинсүрэн Даваасамбуу - Манхан сумын “НИК Петровис ХХК”-ийн түгээгч, эрхлэгч
14. Чойжинжав Нансалмаа - Жаргалант сумын Цамбагарав багийн өндөр настан
15. Шарав Балтав - Жаргалант сумын Тахилт багийн өндөр настан

“Хөдөлмөрийн хүндэт медаль”-иар

1. Төмөрцогт Алимаа - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа удирдлагын хэлтсийн мэргэжилтэн
2. Дамдинсүрэн Бямбасүрэн - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн
3. Баатархүү Гантөмөр - Аймгийн Засаг даргын Тамгын газрын хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн ахлах мэргэжилтэн

- | | |
|---------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------|
| 4. Пүрэвжаргал Цэцэгсүрэн | - Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хууль зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн |
| 5. Хуягт Ганболд | Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Санхүү төрийн сангийн хэлтсийн
төлбөр тооцооны мэргэжилтэн |
| 6. Жанжаа Дэнсмаа | - Аймгийн Засаг даргын Тамгын газрын
үйлчлэгч |
| 7. Лхагваа Алимаа | - Зэрэг сумын Ерөнхий боловсролын
сургуулийн бичиг хэргийн ажилтан |
| 8. Сүхээ Алимаа | - Зэрэг сумын Ерөнхий боловсролын
сургуулийн эмч |
| 9. Даньдай Бадамсайхан | - Зэрэг сумын Ерөнхий боловсролын
сургуулийн бага ангийн багш |
| 10. Дашравдан Болормаа | - Зэрэг сумын Ерөнхий боловсролын
сургуулийн багш |
| 11. Дамдинбазар Наранбат | - Зэрэг сумын Хөндлөн багийн өндөр настан |
| 12. Тумаг Энхсайхан | - Зэрэг сумын Цэцэрлэгийн нярав |
| 13. Авир Энхтайван | - Чандмань сумын Тахилт багийн малчин |
| 14. Чимэддорж Баянцол | - Алтай сумын Тахилт багийн малчин |
| 15. Казваан Нарантуяа | - Үенч сумын Хөх-Үзүүр багийн иргэн |
| 16. Бямба Баасанжав | - Баруун бүсийн Эрчим хүчний салбарт
монтёр жолооч |
| 17. Цэдэн Пүрэвдорж | - Аймгийн хот тохижуулахын газрын
цахилгаанчин |
| 18. Батжаргал Бадамцэрэн | - Мянгад сумын Ерөнхий боловсролын
сургуулийн багш |
| 19. Дамдиндорж Хишигээ | - Мянгад сумын Ерөнхий боловсролын
сургуулийн багш |
| 20. Готовдорж Дамдинжав | - Жаргалант сумын Бугат багийн иргэн |
| 21. Бөхөө Лхамсүрэн | - Манхан сумын Баянгол багийн "Манхан
байгаль ТББ-ын тэргүүн |

ХУРЛЫН ДАРГА



Г.ПҮРЭВГАНДИ